

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гарын үсэг

ТӨРӨӨС ОЛГОХ УРАМШУУЛЛААС ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ СУУТГАН ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрөөс олгох ноосны, сүүний, арьс ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал (цаашид “төрөөс олгох урамшуулал” гэх) авах эрх үүссэн иргэн (цаашид “иргэн” гэх)-ий төлбөл зохих эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн төрөөс олгох урамшууллаас нь суутган төлөхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэхүү журам нь Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хууль болон Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам, Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам, Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журамд нийцсэн байна.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, төрөөс ноосны, сүүний, арьс ширний, улаан буудайн, хүнсний ногооны урамшуулал авах эрх бүхий малчин, мал бүхий иргэд, тариалан эрхлэгч энэхүү журмын хамаарагч талууд байна.

2.2.Төрөөс олгох урамшуулал авах эрх үүссэн иргэн уг урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлөхийг зөвшөөрсөн хүсэлтээ Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (аймаг, нийслэлийн салбар)-д цахимаар гаргасан байна.

2.3.Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх хүсэлт гаргасан иргэн нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр,

тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгоогүй, нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй байна.

Гурав. Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөх хүсэлт гаргах

3.1. Хөдөө аж ахуйн салбарт төрөөс олгож буй сүү, хүнсний ногоо, улаанбуудай, ноос, арьс, ширний мөнгөн урамшуулалд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэд нь нийгмийн даатгалын шимтгэл төлөх хүсэлтээ гаргаж харъяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай сайн дураар гэрээ байгуулсан байна.

3.2. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай сайн дураар байгуулсан гэрээг нийгмийн даатгалын мэдээлэл бүхий мэдээллийн санд байршуулна.

3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урамшууллын цахим системд хүсэлт гаргаж буй иргэдээс шимтгэл тооцож суутгах тухай хүсэлтийг нийгмийн даатгалын мэдээлэл бүхий мэдээллийн сангаас үндэслэн хүлээн авна.

Дөрөв. Төрөөс олгох урамшууллыг тооцох, шимтгэлийг суутгах

4.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.2-т заасан хүсэлтээ гаргасан иргэдийн жагсаалтыг эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус цахимаар хүргүүлнэ.

4.2. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 4.1-д заасан жагсаалтыг үндэслэн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах мөнгөн дүн бүхий мэдээлэл (банкны нэр, код, дансны дугаар, регистрийн дугаар)-ийг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

4.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.2-т заасан мэдээллийн дагуу төрөөс олгох урамшууллаас шимтгэлийг суутган тооцож эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох сангийн харилцах дансанд тухай бүр шилжүүлнэ.

Тав. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх

5.1. Төрөөс олгох урамшууллаас дараах байдлаар шимтгэлийг суутган төлнө.

5.1.1. Энэ журмын 2.2-т заасны дагуу цахимаар хүсэлтээ гаргасан иргэн төрөөс олгох урамшууллаас 2019 он болон түүнээс хойшхи хугацаанд ногдох эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

5.1.2. Нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээний хугацаанд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн нийт төлөгдөөгүй шимтгэлийг тус тус суутган төлнө.

5.2. Төрөөс олгох урамшууллаас иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг суутгасны дараах олговол зохих урамшууллаас нь нийгмийн даатгалын шимтгэлийг суутган төлнө.

Санамж: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т “Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна.” гэж заасан.

5.3. Иргэн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, төрөөс олгох урамшууллаас шимтгэл төлөхөд холбогдох хууль тогтоомжийг баримтална.

5.4. Урамшуулаас шимтгэлээ суутган тооцуулах хүсэлтээ гаргасан даатгуулагч шимтгэлээ илүү төлсөн бол дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд шилжүүлэн тооцох эсхүл илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг бүртгэх, тооцоо нийлэх, тайлагнах

6.1. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэний шимтгэл төлөлтийг мэдээллийн санд даатгуулагч бүрээр бүртгэнэ.

6.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь шилжүүлсэн шимтгэлийн дүн, хүлээн авсан дүнг жил бүр тооцоо нийлж ажиллана.

6.3. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нь урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэний тайланг хагас жил тутам гаргаж харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урамшуулалд хамрагдах, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хамрагдах шимтгэл суутган тооцох даатгуулагчийг тодорхойлох, бүртгэх, шимтгэл суутган тооцох үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Найм.Бусад

8.1.Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой аргачлалыг эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь баталж болно.

8.2.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор холбогдох мэдээллийг харилцан солилцож болно.

8.3.Төрөөс олгох урамшууллаас шимтгэл суутган төлөхтэй холбоотой үүссэн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд холбогдох газрууд хамтран шийдвэрлэнэ.

---o0o---